



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/12

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠨᠢᠶᠭᠦᠮ,
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠪᠠᠶᠳᠠᠯ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2016 оны 12 дугаар сарын байдлаар)


Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

2016 оны эцэст 66.6 мянган байнгын оршин суугчтай болж 2015 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 5.5 хувиар буюу 3481 хүнээр өссөн байна. 2000 оны хүн амын тооллогоос хойш жилд дунджаар 1.76 хувь буюу 16.0 мянган хүнээр, 2010 оны хүн амын тооллогоос хойш жилд дунджаар 1.4 хувь буюу 8.7 мянган хүнээр нэмэгджээ.

Зураг. Хүн амын тоо, өсөлтийн хувь, жил бүрийн эцэст



Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлт, сумаар, 2010-2016 онд




Дорноговь аймгийн хүн амын тоо 1979-1989 онд бүх сумдын хүн ам жигд өссөн, 1989-2000 оны хооронд Иххэт, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдаас бусад 10 сумын хүн амын тоо, 2000-2010 онд Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын хүн амын тоо өссөн байна. 2010-2016 онд Айраг, Иххэт, Хатанбулаг

сумын хүн амын тоо 0,24-0,61 хувиар буурч бусад сумдын хүн амын тоо жилд дунджаар 0.20-4.71 хувиар өслөө.

Замын-Үүд сумын хүн амын тооны өсөлт 2000-2010 онд жилд дунджаар 9.25 хувь, 2010-2016 онд 4.71 хувь буюу өсөлтийн хувь хамгийн өндөр сум хэвээр байна.


Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь



Дорноговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 1969-1979 онд 3.25 хувиар өсч байсан нь хамгийн их өсөлттэй үе байсан бол 1989-2000 онд хүн амын тоо жилд дунджаар 1.10 хувиар буурч байв. 2010-2016 онд энэ үзүүлэлт 235 хувь байна.

Хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах гол үзүүлэлтийн нэг бол нас, хүйсийн суварга билээ.

Зураг. Дорноговь аймгийн хүн амын нас, хүйсний суварга




2010 онд манай аймгийн хүн амд 5-19 насныхны эзлэх хувь 2000 онтой харьцуулахад буурсан нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурснаар тайлбарлагдаж байсан бол 2016 онд хадгалагдсан хэвээр 10-24 насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь бага байсаар байна.

0-4 насны хүн амын эзлэх хувь 2010 оны мөн үетэй ойролцоо байгаа нь хүн амын нас хүйсийн суваргаас харагдаж байна. Сүүлийн 5 жилд төрсөн хүүхдийн тоо 2010 оны сүүлийн 5 жилд төрсөн хүүхдийн тоотой харьцуулахад 21,4 хувиар өссөн хэдий ч хүн амд эзлэх хувьд өөрчлөлт гараагүй байгааг 0-4 насны хүүхдийн өөр аймаг, нийслэл рүү шилжилт нэмэгдсэнээр тайлбарлаж болох юм.

Суурин хүн амын 50.0 хувь нь эрэгтэйчүүд, 50.0 хувь нь эмэгтэйчүүд юм. Нийт хүн амын 62.4 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 14.2 хувь нь сумын төвд, 23.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Хот тосгонд амьдарч буй хүн амын тоо өмнөх оноос 0.8 пунктээр өсч, сумын төвд амьдарч буй хүн амын тоо 0.5 хувиар, хөдөөд амьдарч буй хүн амын тоо 0.3 пунктээр буурчээ. 109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 66.6 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.61 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.

Зураг. Хүн амын насны бүтэц, хувиар 2000, 2010, 2016 он




Дорноговь аймгийн хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жин 2016 онд 2000 оныхоос өөрчлөгдсөн байна. 2000 онд хүн амын 36.2 хувийг хүүхэд (0-14нас), 60.3 хувийг хөдөлмөрийн насны (15-64нас), 3.5 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байсан бол 2016 онд 30.7 хувийг хүүхэд, 63.7

хувийг хөдөлмөрийн насны, 5.6 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзлэж байна. 2010 оны хүн амын орон сууцны тооллогын дүнтэй хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жинг харьцуулахад 0-14 насны хүхэд 1.1 пунктээр, тэтгэвэрийн насны хүн ам 0.8 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн ам 1.9 пунктээр буурлаа.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүн ам зүйн ачаалал 1979 онд 99.5 хувь, 1989 онд 90.9 хувь, 2000 онд 66.0 хувь, 2010 онд 48.8 хувьд хүрч тооллогоос тооллогын хооронд буурч байсан бол 2016 онд 56.9 болж нэмэгдсэн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2012-2016 он



2016 онд Дорноговь аймагт 805 хүү, 722 охин нийт 1527 шинэ хүн мэндэлж, 391 хүн нас барж хүн амын цэвэр өсөлт 1136 болжээ. Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 140-өөр буурч, нас барсан хүний тоо 41-ээр өссөн байна.

Төрсөн хүүхдийн хүйсний харьцаа 111.5 нас барсан хүний хүйсний харьцаа 160.7 байна. Монгол Улсын хүн ам зүйн олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 103-104 хооронд байдаг зүй тогтолтой. Амьдралын эхний жилүүдэд эрэгтэй хүүхдийн нас баралт илүү байж, цаашдаа хүйсийн харьцаа тэнцвэржиж байснаа нас ахих тутам буурдаг ажээ. Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) 2016 онд 99.9 байгаа нь 2015 оны үзүүлэлтээс 0.2 пунктээр их байна. Хүйсийн харьцаа 44-өөс дээш насанд, нас ахих тутам буурч байснаа 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 52.2 түүнээс бага болж огцом буурсан байна. Энэ нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй их байдагтай холбоотой. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалдаг.



1.2. Өрхийн зарим үзүүлэлт


2016 оны эцэст 20299 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 1.4 хувиар буюу 281 өрхөөр нэмэгдэж нэг өрхөд ногдох хүний тоо 3.3 байна.

2010 оны тооллогоор нийт өрхийн 58.6 хувь нь аймгийн төв, тосгонд, 41.4 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байсан бол 2016 онд 59.8 хувь нь аймгийн төв, тосгонд, 40.2 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байгаа нь хотожсон аймаг болохыг харуулж байна.

Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийг 2015 онтой харьцуулахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 4.4 хувиар, тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо 16.7 хувиар буурч, гэр бүлгүй өрх толгойлсон эрэгтэйчүүдийн тоо 2.6 хувиар, ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 5.9 хувиар нэмэгдэж, 2 ихэр хүүхэдтэй өрхийн тоо 16.6 хувиар буюу 28-аар нэмэгдсэн үзүүлэлт гарлаа.

Өнчин хүүхдийн тоо 2016 онд 755 болж 2015 оноос 28-аар нэмэгдэж, 2012 оноос 9-өөр буурлаа. Нийт өнчин хүүхдийн 7.9 хувь буюу 60 нь бүтэн өнчин, 92.1 хувь буюу 695 нь хагас өнчин хүүхдүүд юм.

Зураг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 2012-2016 он



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2470 болж өмнөх оныхоос 3.1 хувиар буурсан байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.7 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байгаа бол 75.7 хувь нь төрөлхийн, 24.3 хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.



1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны эцэст 1503 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.5 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 811 буюу 53.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 4.2 пунктээр буурчээ. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 38.1 хувь нь бүрэн дунд, 26.0 хувь нь дээд, 11.6 хувь нь бүрэн бус дунд, 10.4 хувь нь тусгай дунд, техник болон мэргэжлийн, 11.0 хувь нь 1,9 хувь нь бага, 0,9 хувь нь боловсролгүй, 0.7 хувь нь магистр докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 28 ажлын байрны 60,7 хувь нь ХАА, ой, загас агнуурын ажилтан, 32,1 хувь нь энгийн ажил мэргэжил, 7,2 хувь нь бусад ажил мэргэжлын захиалга байна.

Ажилгүй 343 иргэн ажилд зуучлагдан орсоны 42,0 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймгийн дүнгээр 459 шинэ ажлын байр бий болсоны 349 нь буюу 76,0 хувь нь байнгын ажлын байртай болжээ.



1.4 Нийгмийн даатгал, халамж

2016 онд нийгмийн даатгалын санд 25604,4 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеэс 15,6 хувиар нэмэгдсэн байна.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2016 онд



Тэтгэврийн даатгалын сангаас 27583,5 сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2353,7 сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 6490,3 сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1725,2 сая. төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 846,9 сая.төг, нийт 38999,6 сая.төгрөгийг зарцуулжээ.

2016 онд нийгмийн халамжийн сангаас 16 909 иргэнд 5 863,2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй 3 146 эхэд 737,9 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон байна. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу 3 245 иргэнийг нэг удаагийн тусламж үйлчилгээнд хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 9,6 хувиар буурсан байна.

Зураг. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ /төрлөөр/, 2016 оны 12 сард





1.5 Эрүүл мэнд

Он гарсаар 396.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар, 15.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 17.8 хувиар өсч, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүний тоо 14.5 мянга байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурлаа.

Энэ онд 1414 эх жирэмсний хяналтанд орсны 85.4 хувь буюу 1208 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ.

Түргэн тусламжийн дуудлага 20.4 мянган удаа гарсны 3.5 мянга буюу 17.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 7.4 хувиар, алсын дуудлага 12.9 хувиар нэмэгджээ.

Он гарсаар ослын улмаас 2367 хүн бэртэж, 83 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ослын улмаас бэртсэн хүний тоо 1.4 хувиар буурч, нас барсан хүний тоо 9-өөр буурсан байна.

Халдварт өвчний 1742 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс буюу 97.3 хувиар буюу 859-өөр нэмэгджээ.



1.6 Боловсрол

2016/2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 21 сургуульд 12278, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 623, АШУҮИС-д 654 бүгд 13586 оюутан, сурагч суралцаж байна. Энэ нь өмнөх оноос 1.4 хувиар буюу 191-ээр илүү байна.

2016/2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 1368, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд 131, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд 300 оюутан, сурагч шинээр элсэн суралцлаа.



1.7 Байгаль орчин

Цаг уур

2016 оны 12 дугаар сард нийт нутгаар агаарын дундаж температур өдөртөө 10.6 хэм хүйтэн, шөнөдөө агаарын температур Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад 19-22 хэм хүйтэн, Дэлгэрэх, Алтанширээ сумдад 29-33 хэм хүйтэн, өдөртөө Хөвсгөл, Хатанбулаг сумдад 1-3 хэм дулаан, бусад сумдын нутгаар 2-7 хэм хүйтэн байлаа. Энэ сард нийт нутгаар 0.2-2.7 мм хур тунадас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг ОЖД-тай харьцуулахад: Өргөн, Замын-Үүд, Улаанбадрах, Мандах, Иххэт сумдад ОЖД-аас ахиу, Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдад ОЖД-аас бага цас орсон байна. Цасны дундаж зузаан Замын-Үүд суманд 2, Улаанбадрах, Эрдэнэ, Мандах, Хөвсгөл сумдад 1-3 см, бусад сумдад 1-5 баллын цасан бүрхүүлтэй байна.



1.8 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2016 онд 665 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 34 хүн нас барж, 282 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 18.5 хувь буюу 104-өөр нэмэгдсэн байна.

Хэргийн төрлөөр үзвэл өмнөх оны мөн үеэс дээрмийн гэмт хэрэг, иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, ашиглал, танхай, албан тушаалын гэмт хэргүүд нэмэгдлээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 33,5 хувийг иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 31,1 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 9,5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3,8 хувийг танхайн гэмт хэрэг, 1,4 хувийг хүн амины гэмт хэрэг, 20,7 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Нийт гэмт хэргийн 32,8 хувь буюу 218 нь согтуугаар үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг сумдад буурч, Хөвсгөл суманд адил хэмжээнд, бусад сумдад нэмэгдлээ. Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2091,4 сая төгрөгийн хохирол учирсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 906,4 сая төгрөгөөр буюу 76,5 хувиар нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 73,9 хувь буюу 1545,6 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 32,8 хувийг согтуугаар, 33,1 хувийг гэр сууцандаа, 17,7 хувийг гудамж олон нийтийн газарт, 6,2 хувийг бүлэглэн, 16,1 хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 38,6 хувийг шөнө, оройн цагаар /19-22, 22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1450 хүн саатуулагдаж, 58 хүн баривчлагджээ.

Хоёр. Эдийн засгийн үзүүлэлт



2.1 Төрийн санхүү

2016 оны 12 сарын дүнгээр орон нутгийн төсөвт 46302.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Орон нутгийн төсвийн орлогын 32.4 хувийг татварын, 67.6 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 81.6 хувиар биелсэн байна.

Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт 3303.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.




2.2 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 991.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 16.7 хувь, цэвэр зарлага 773.9 тэрбум төгрөг болж 34.3 хувиар буурчээ.


Иргэдийн мөнгөн хадгаламж 60.4 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчдэд дундажаар 909.4 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 906.7 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 4.0 хувиар буурч, хадгаламжийн үлдэгдэл 29.6 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн өрийн үлдэгдэл 6.5 хувиар нэмэгдэж, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 66.1 хувиар буурч, чанаргүй зээлийн үлдэгдэл 59.1 хувиар нэмэгджээ.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2015-2016 он, мян.хүн



Зураг.Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2015-2016 он, сая.төг





2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2016 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 2,0 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт1. Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 12 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	ЖИН	2016-12 2010-12	2016-12 2014-12	2016-12 2015-12	2016-12 2016-11
Ерөнхий индекс	100.0	161.1	99.6	102.0	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	36.0	149.4	89.9	102.4	100.2
Согтууруулах ундаа, тамхи	2.5	209.4	98.3	103.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	18.0	235.0	110.0	104.5	101.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.6	137.0	96.3	95.7	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	6.2	148.8	105.5	100.8	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.6	124.9	103.2	105.3	103.1
Тээвэр	14.3	134.1	103.9	99.8	100.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.9	103.2	102.4	102.4	100.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.1	95.7	100.5	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	0.2	375.0	139.7	110.5	100.0
Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	0.8	302.0	122.5	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	3.9	160.6	102.9	101.9	100.6


Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.7 хувиар өсөхөд: Хүнсний бараа, ундаа, усны бүлэг 0.2 хувь, хувцас, бөс бараа гутал 1.8 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ 3,1 хувиар, тээвэр 0,6 хувь, бусад бараа үйлчилгээ 0,6 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Харин.согтууруулах ундаа, тамхи,орон сууц, ус, цахилгаан, түлш,гэр ахуйн тавилга, бараа, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, зочид буудал зоогийн газар, дотуур байр бүлгүүд тогтвортой байна.


Хүснэгт. Хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа,үйлчилгээний бүлэг	үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим бараа үйлчилгээний үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	0.2	Хүнсний ногоо 6.8 хувь, саахар жимсний чнамал 1.6 хувь,хүнсний бусад бүтээгдэхүүн 2.9 хувиар тус тус өсч, мах махан бүтээгдэхүүн 0.7 хувь, сүү сүүн бүтээгдэхүүн өндөг, 0.9 хувь төрөл бүрийн өөх тос 0.8 хувь, жимс жимсгэнэ 0.9 хувь, согтууруулах бус ундаа2.1 хувиартус тус буурсан.
Хувцас, бөс бараа, гутал	1.8	хөвөн бөс бараа 0.2 хувь, бүх төрлийн хувцас 2.0 хувь, гутал 1.3 хувь өссөн нь нөлөөлсөн
Эм тариа эмнэлэгийн үйлчилгээ	3.1	эм тариа эмнэлэгийн хэрэгслийн 3.4 хувь өссөн
Тээвэр	0.6	хувийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ 2.8 хувь өссөн
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.3	интернэтийн үйлчилгээ
Бусад бараа үйлчилгээ	0.6	хувь хүнд хандсан үйлчилгээ 0.6 хувь, хүний эд зүйл хэрэглэл 0.9 хувь тус тус өссөн нь нөлөөлсөн

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 12 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015 - 2016 оны сар бүрээр (өмнөх сар=100)



2.4 Хөдөө аж ахуй

2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1752.9 мянган толгой мал тоологдсоны дотор 37.7 мянган тэмээ, 181.7 мянган адуу, 63.0 мянган үхэр, 758.4 мянган хонь, 775.2 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо өмнөх оноос 2.7 хувь буюу 48.3 мянган толгойгоор буурчээ. Мал сүргийн тоог таван төрлөөр авч үзвэл тэмээ 4.4 хувь, хонь 0.9 хувиар өсч, ямаа 4.6 хувь, адуу, үхэр 9.8 хувиар буурсан байна..

Жил бүрийн эцсийн мал тооллогын дүнг харахад аймаг байгуулагдсан 1931 оноос нэг саяас дээш мал тоолуулсан 23 дах жил байлаа.

Зураг . Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой



Сүргийн бүтцэд ямаа 44.2 хувийг, хонь 43.3 хувийг, үхэр 3.6 хувийг, адуу 6.8 хувийг, тэмээ 2.2 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад тэмээ, хонины эзлэх хувь 0.1-1.5 пунктээр өсч, тэмээ, үхэр, ямааны эзлэх хувь 0.1,0.3,0.9 пунктээр буурсан байна.


Аймгийн хэмжээгээр 1000–аас дээш малтай өрхийн тоо 314 болж өмнөх оноос 24 өрхөөр буурчээ. 1000 –аас дээш малтай өрх Сайхандулаан суманд 39, Иххэт суманд 35, Дэлгэрэх суманд 32, Даланжаргалан суманд 29, Өргөн суманд 28 тоологдсон нь хамгийн олон нь байсан бол 2000-3000 малтай өрх Айраг суманд 5 өрх, Дэлгэрэх суманд 3 өрх, Иххэт, мандах суманд тус бүр 2, Замын-Үүд, Өргөн сумдад тус бүр 1 өрх тоологджээ.

Аминдаа малтай 5141 өрх байгаагийн 80.5 хувь буюу 4137 нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж байгаа малчин өрх байна. Малчин нэг өрхөд 390, малтай нэг өрхөд 336 толгой мал ногдож байгаа нь 2015 оноос малчин нэг өрхөд ногдох мал 23 толгой, малтай нэг өрхөд ногдох мал 16 толгой малаар буурчээ. Малчдын тоо 2016 онд 7477 болж өмнөх оноос 3.5 хувиар буюу 256 – аар нэмэгджээ.

2016 онд оны эхнийнийт хээлтэгч малын 71.2 хувь буюу 550.6 мянган эх мал төллөж, гарсан төлийн 92.8 хувь буюу 518.2 мянган төл бойжжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад бойжсон төл 9.6 хувиар цөөн байна.

2016 онд 118.0 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 6.6 хувьтай тэнцэж байна. Айраг, Дэлгэрэх, Өргөн, Хөвсгөл сумдад хорогдсон малын тоо нийт хорогдлын 53.8 хувийг эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, мянган толгойгоор, 2000-2016 он



2016 онд тэжээвэр амьтан өсгөн үржүүлдэг өрхийн тоо 42 болж өмнөх оноос 12-оор өсчээ. 169 гахай, 2063 шувуу тоологдсон нь өмнөх оноос гахай 2 дахин, шувуу 1.7 дахин өссөн байна. Тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрхүүд 1.2 тонн гахайн мах бэлтгэж, 18460.0 мянган төгрөг, 166.9 мянган ширхэг өндөг бэлтгэж 491.0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Энэ онд 17 худаг шинээр гаргахад 613.5 сая төгрөг, 145 худаг сэргээн засварлахад 90.9 сая төгрөг зарцуулсан байна.

Малжуулах арга хэмжээнд 139 өрхийг хамруулж нийт 8580 толгой мал олгосны 98.6 хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 55 өрхөөр буурч, нэг өрхөд дундажаар 61 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 8 толгойгоор нэмэгдсэн үзүүлэлт байна.

Нийт малчин өрхийн 82.3 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 71.2 хувь нь телевизиртэй, 52.9 хувь нь автомашинтай, 51.2 хувь нь мотоциклтой мөн 79.1 хувь гар утас ашигладаг дүн гарчээ. Өмнөх оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрх 3.5 хувиар, гар утас хэрэглэдэг өрхийн тоо 1.5 хувиар нэмэгдэж, телевизортой өрх 0.5 хувиар, автомашинтай өрх 2.4 хувиар, мотоциклтой өрх 1.8 хувиар буурсан байна.

2016 онд 28.8 га талбайд төмс, 51.7 га-д хүнсний ногоо тариалж, 202.3 тн төмс, 264.5 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 24.6 тн-оор, хүнсний ногоо 48.4 тн-оор бага байна. 1 га-аас 7.0-5.1 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2015 оноос төмс 0.1 тн-оор, хүнсний ногоо 1.7 тн-оор буурсан байна. Тайлант онд 6565.0 тн өвс хадлан, 129.5 тн гар тэжээл, 204.8 тн хужир шүү тэжээл бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 57.8 хувиар нэмэгдэв.



2.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт оны эхний 12 сард оны үнээр 33135.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 55611.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнө онтой харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлт 3



дахин, борлуулалт 4 дахин өслөө. Үүнд уул уурхай олборлолт, цементийн үйлдвэрлэл 22626.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 7154.9 сая төгрөг болж, өмнөх оноос 83,6 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 27,3 хувийг төрийн, 72,7 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэсэн байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 27,3 хувь, компани 70,9 хувь, хоршоо 0,02 хувь, өрхийн аж ахуй 1,8 хувийг тус тус үйлдвэрлэжээ.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 11.1 мян.ккал-аар, ус түгээлт 139.0 мян м3, сүүн бүтээгдэхүүн 10.9 мян.тн-оор, хэрчсэн гурил 7.2 мян.тн-оор, зайрмаг 0.4 мян.ширх-ээр, нүүрс 409,3 мян.тн-оор, цемент 79.5 мян.тн-оор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



2.7 Тээвэр, Холбоо

2016 онд 85.3 мянган тонн ачаа тээвэрлэж, 18818.0 мянган тонн км-ын ажил, 51.3 мянган зорчигч тээвэрлэж 1242.0 мянган хүн км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 6781 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 4.5 хувиар нэмэгдсэн байна.

2016 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр 19967 авто машин, тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оноос 39.9 хувь буюу 5.6 мянгаар нэмэгджээ. Нийт тээврийн хэрэгслийн 69.3 хувийг суудлын, 13.2 хувийг ачааны автомашин, 2.2 хувийг автобус, 2.0 хувийг мотоцикл, 5.9 хувийг тусгай зориулалтын автомашин, 6.6 хувийг чиргүүл, 0.6 хувийг бусад механизмууд эзэлж байна. Харин 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор малчин өрхүүдэд тоологдсон мотоциклын тоог техникийн хяналт оношлогооны дүнтэй харьцуулж үзэхэд аймгийн хэмжээний 5 мотоцикл тутмын 1 нь хяналт оношлогоонд хамрагдсан дүн гарчээ.

Шуудан холбооны үйлчилгээний орлого 1332.8 сая төгрөг болж өмнөх оноос 11.7 хувиар буурсан байна. Суурин телефон цэгийн тоо 2016 онд 2218 болж өмнөх оноос 9.4 хувиар буюу 231 хэрэглэгчээр буурсан байна. Энэ онд нийт 10.3 мянган ширхэг албан бичиг, захидал, 417 ширхэг илгээмж (боодол) илгээсэн бол шуудангаар 357 зорчигч үйлчлүүлж 4.4 сая төгрөгийн орлого оруулжээ.

Аймгийн хэмжээнд 6 кабелийн болон эфирийн телевиз үйлчилгээ үзүүлж нийт 281.5 сая төгрөгийн орлого оруулж, 4615 гаруй хэрэглэгчдэд үйлчилж байна. Байршлаар нь авч үзвэл Сайншанд суманд 4, Замын-Үүд суманд 1, Өргөн, Иххэт суманд 1 кабелийн телевизийн цэг ажиллаж байна.

2016 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 14, скайтелын


13, G-mobile 12, суурин телефон цэг 7 суурин газарт нийт 61 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ. Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 4119.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 14.2 хувиар өсчээ. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 69.7 мянга орчим байгаа нь өмнөх оноос 2.2 мянган хэрэглэгчээр нэмэгджээ.



2.8 Барилга угсралт, их засвар

2016 онд нийт 17046,2 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 59,6 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15,1 хувийг улсын төсвийн, 16,7 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, мян төг



Барилга угсралт их засварын ажлын 28,9 хувь нь орон сууцны барилга, 40,2 хувь нь орон сууцны бус барилга, 27,9 хувь нь инженерийн барилга, байгууламж, 3,0 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 9,9 пунктээр буурч, орон сууцны барилгын эзлэх хувь 6,9 пункт, орон сууцны бус барилгынх 2,7 пункт, их засварын ажлынх 0,3 пунктээр өссөн байна.



АГУУЛГА

I. Аймгийн эдийн засаг, нийгмийн зарим гол нэгдсэн үзүүлэлтүүд

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл
(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Хүн ам

- 1.1 Суурин хүн амын тоо, хүйс, байршлаар, оны эцэст
- 1.2 Суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, оны эцэст
- 1.3 Суурин хүн амын нас, хүйсний бүтэц, хувиар, оны эцэст
- 1.4 Суурин хүн амын тоо, сумаар, хүйсээр, оны эцэст
- 1.5 Суурин хүн амын тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.6 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.7 Хүн амын тоо, сумаар, байршлаар, 2016 онд
- 1.8 Хүн амын тоо, сумаар, насны ангиллаар, 2016 онд
- 1.9 Хүн амын төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, сумаар, оны эцэст
- 1.10 Төрсөн, нас барсан, гэрлэсэн, гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо, оны эцэст
- 1.11 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, оны эцэст
- 1.12 1000 хүнд ногдох төрөлт, сумаар, оны эцэст
- 1.13 1000 хүн амд ногдох нас баралт, сумаар, оны эцэст
- 1.14 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.15 Өрхийн нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст
- 1.16 Хүн амын нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст

Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6 Шинээр бий болгосон ажлын байр, эдийн засгийн салбарын ангилалаар

Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Дөрөв. Боловсрол

- 4.1 Бүх шатны сургуульд саралцагчид
- 4.2 Бүх шатны сургуульд элсэгчид
- 4.3 Бүх шатны сургууль төгсөгчид

Тав. Эрүүл мэнд

- 5.1 Эрүүл мэндийн үзүүлэлт
- 5.2 Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо, сумаар
- 5.3 Нялхсын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдохоор, сумаар

Зургаа. Соёл

- 6.1 Соёл

Долоо. Байгаль орчин

- 7.1 Цаг уурын үзүүлэлтүүд

Найм. Гэмт хэрэг

- 8.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 8.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар
- 8.3 Малын хулгайн хэргийн тоо, сумаар, оны эцэст
- 8.4 18-аас дээш насны 1000 хүнд ногдох гэмт хэргийн тоо, сумаар
- 8.5 Гал түймрийн тоо, учирсан хохирол, шалтгаан

Ес. Мөнгө, банк

- 9.1 Мөнгөн гүйлгээ, сая төгрөгөөр

Арав. Төрийн санхүү

- 10.1 Орон нутгийн төсвийн орлого, сая. төгрөгөөр
- 10.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая. төгрөгөөр
- 10.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумаар
- 10.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая. төгрөгөөр



Арван нэг. Үнэ

- 11.1 Хэрэглээний үнийн индекс
- 11.2 Хэрэглээний бараа , үйлчилгээний үнэ тариф
- 11.3 Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, аймгуудаар
- 11.4 Гол нэрийн барааны дундаж үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар
- 11.5 Улаанбаатар хотод зарагдаж байгаа автобензин, дизелийн түлшний үнэ
- 11.6 Аймгийн төвүүдэд зарагдаж байгаа автобензин, дизелийн түлшний үнэ

Арван хоёр. Хөдөө аж ахуй

- 12.1 ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
- 12.2 Мал сүргийн өсөлтийн үзүүлэлт
- 12.3 Малын тоо, сумаар, төрлөөр
- 12.4 Малчдын тоо, сумаар, мал тооллогын дүнгээр
- 12.5 Малчин өрхийн нийгэм ахуйн зарим үзүүлэлт
- 12.6 Малчин өрхийн малын бүлэглэлт, мал тооллогын дүнгээр
- 12.7 Малтай болон малчин өрхийн тоо, сумаар
- 12.8 Хамгийн олон малтай сум, таван төрлөөр
- 12.9 Хамгийн олон малтай баг, таван төрлөөр
- 12.10 Хамгийн олон малтай өрх, таван төрлөөр
- 12.11 Малын тоо толгойн дээд хэмжээ хүрсэн онууд
- 12.12 1000-с дээш малтай өрхийн судалгаа
- 12.13 Газар тариалангийн үйлдвэрлэл
- 12.14 Газар тариалангийн үйлдвэрлэл сумаар
- 12.15 Шинээр гаргасан болон сэргээн засварласан худгийн тоо
- 12.16 Малжуулалтанд хамрагдсан өрх
- 12.17 Багуудын зарим үзүүлэлтүүд, оны эцэст

Арван гурав. Аж үйлдвэр

- 13.1 Нийт бүтээгдэхүүний оны өсөлт, 2005 оны зэрэгцүүлэх үнээр
- 13.2 Нийт ба борлуулсан бүтээгдэхүүн, сая.төг
- 13.3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, гол нэр төрлөөр, аймгийн дүнгээр
- 13.4 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, гол нэр төрлөөр, сумаар
- 13.5 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар, сая төгрөг
- 13.6 Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж, дэд салбараар, сая төгрөг

Арван дөрөв. Тээвэр харилцаа, холбоо

- 14.1 Авто тээвэр, оны эцэст
- 14.2 Холбоо, шуудан, оны эцэст
- 14.3 Үүрэн телефон, оны эцэст
- 14.4 Кабелийн телевиз, оны эцэст
- 14.5 Телефон утасны сүлжээний байршил
- 14.6 Нефть хангамж, оны эцэст

Арван тав. Барилга угсралт, орон сууц, нийтийн аж ахуй

- 15.1 Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, оны эцэст
- 15.2 Барилга угсралт, их засварын ажил, оны эцэст
- 15.3 Барилга угсралт их засварын ажил, объектээр

Тэмдэглэлийн тайлбар :

- (,,) - тухайн тоо, баримт байхгүй
- (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- (x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	2012	2013	2014	2015	2016	2016 - 2015	$\frac{2016}{2015}$
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	60.9	62.5	63.5	63.1	66.6	3.5	105.5
- Төрсөн хүүхдийн тоо**	1587	1582	1673	1667	1527	-140	91.6
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	1587	1582	1673	1667	391	-1276	23.5
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	1214	1208	1286	1317	1136	-181	86.3
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	23	23	20	19	21	2	110.5
- 1000 хүүхдэд ноогдох	14.5	14.5	12.0	11.4	13.8	2.4	120.7
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	904	1265	1 452	1 227	1 503	276	122.5
- Үүнээс эмэгтэй	404	725	858	713	811	98	113.7
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	226	323	360	300	364	64	121.3
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	1015	1012	1072	1075	459	-616	42.7
Үүнээс: Байнгын ажлын байр	718	602	879	876	349	-527	39.8
Улирлын чанартай ажлын байр	297	410	193	199	110	-89	55.3
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	1014	1043	842	883	1742	859	197.3
- 10000 хүнд ногдох	168	171	135	139	269	129.8	193.3
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	582	559	527	561	665	104	118.5
- 10000 хүнд ногдох ***	136	142	127	139	155	15.7	111.3
8. Малын тоо - Бүгд мянган толгой	1327.9	1516.3	1686.8	1801.2	1752.9	-48	97.3
- Тэмээ	31.4	32.8	34.8	36.1	37.7	2	104.4
- Адуу	95.6	107.0	120.8	131.6	118.7	-13	90.2
- Үхэр	50.3	59.4	65.4	69.9	63.0	-7	90.1
- Хонь	531.5	611.9	690.7	751.4	758.4	7	100.9
- Ямаа	619.1	705.2	775.0	812.2	775.2	-37	95.4
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн(сая.төг)	11666.1	9852.6	11067.4	10509.3	33135.8	22626.5	315.3
- Борлуулсан бүтээгдэхүүн (сая.төг)	3194.4	3779.2	4074.5	12141.8	55611.5	43469.7	458.0

* - 2012, 2013, 2014,2015,2016 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

**II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН
ТУХАЙ СТАТИСТИКИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ**
(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

НЭГ. ХҮН АМ

1.1 СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс байршлаар, мян.хүн, оны эцэст

	2011	2012	2013	2014	2015	2016	$\frac{2016}{2011}$	$\frac{2016}{2015}$
Суурин хүн ам, хүйсээр								
Бүгд	60.5	60.9	62.5	63.5	63.1	66.6	110.1	105.5
үүнээс: -эрэгтэй	30.2	30.4	31.2	31.7	31.5	33.3	110.3	105.7
-эмэгтэй	30.3	30.5	31.3	31.8	31.6	33.3	109.9	105.4
Хүйсний харьцаа	99.7	99.9	99.5	99.9	99.7	100.0		
Хот, хөдөөгийн хүн ам								
- хот, сууринд	35.6	36.1	37.9	39.0	38.9	41.6	116.9	106.9
- хөдөөд	24.9	24.8	24.6	24.5	24.2	25.0	100.4	103.3
Жилийн дундаж суурин хүн ам								
бүгд	60.2	60.7	61.7	63.0	63.3	64.9	107.8	102.5
үүнээс: -эрэгтэй	30.0	30.3	30.8	31.4	31.6	32.4	108.0	102.5
-эмэгтэй	30.2	30.4	30.9	31.5	31.7	32.5	107.6	102.4

1.2 СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, оны эцэст

Насны бүлэг	2013		2014		2015		2016	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Бүгд	62484	31326	63492	31769	63125	31623	66606	33304
0-4	7405	3653	7616	3701	8145	3954	8120	3907
5-9	5814	2861	6170	3042	6630	3251	7123	3485
10-14	5234	2612	5057	2530	4960	2510	5180	2600
15-19	5268	2672	5116	2557	4935	2471	5155	2614
20-24	6162	3013	5826	2876	5305	2565	5302	2587
25-29	6426	3109	6512	3147	6235	3044	6514	3163
30-34	5434	2553	5617	2617	5593	2645	6095	2918
35-39	4878	2431	5065	2491	4868	2360	5234	2497
40-44	4079	2025	4231	2117	4124	2090	4637	2324
45-49	3553	1871	3523	1868	3534	1829	3718	1921
50-54	3072	1617	3180	1655	3022	1593	3273	1717
55-59	2051	1082	2248	1203	2362	1303	2514	1367
60-64	1148	611	1303	701	1327	710	1562	850
65-69	634	367	681	400	748	426	824	458
70-89	1292	823	1310	833	1296	840	1312	862
90+	34	26	37	31	41	32	43	34
0-14 нас	18453	9126	18843	9273	19735	9715	20423	9992
15-59 нас	40923	20373	41318	20531	39978	19900	42442	21108
60+	3108	1827	3331	1965	3412	2008	3741	2204

1.3 СУУРИН ХҮН АМЫН НАС, ХҮЙСНИЙ БҮТЭЦ, хувиар, оны эцэст

насны бүлэг	2013		2014		2015		2016	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-4	11.9	11.7	12.0	11.6	12.9	12.5	12.2	11.7
5-9	9.3	9.1	9.7	9.6	10.5	10.3	10.7	10.5
10-14	8.4	8.3	8.0	8.0	7.9	7.9	7.8	7.8
15-19	8.4	8.5	8.1	8.0	7.8	7.8	7.7	7.8
20-24	9.9	9.6	9.2	9.1	8.4	8.1	8.0	7.8
25-29	10.3	9.9	10.3	9.9	9.9	9.6	9.8	9.5
30-34	8.7	8.1	8.8	8.2	8.9	8.4	9.2	8.8
35-39	7.8	7.8	8.0	7.8	7.7	7.5	7.9	7.5
40-44	6.5	6.5	6.7	6.7	6.5	6.6	7.0	7.0
45-49	5.7	6.0	5.5	5.9	5.6	5.8	5.6	5.8
50-54	4.9	5.2	5.0	5.2	4.8	5.0	4.9	5.2
55-59	3.3	3.5	3.5	3.8	3.7	4.1	3.8	4.1
60-64	1.8	2.0	2.1	2.2	2.1	2.2	2.3	2.6
65-69	1.0	1.2	1.1	1.3	1.2	1.3	1.2	1.4
70-89	2.1	2.6	2.1	2.6	2.1	2.7	2.0	2.6
90+	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
0-34 нас	66.8	65.4	66.0	64.4	66.2	64.6	65.3	63.9
35-59 нас	28.2	28.8	28.7	29.4	28.4	29.0	29.1	29.5
60< нас	5.0	5.8	5.2	6.2	5.4	6.3	5.6	6.6

1.4 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумаар, хүйсээр, оны эцэст

	2013		2014		2015		2016	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Бүгд	62484	31326	63492	31769	63125	31623	66606	33304
Айраг	3590	1811	3607	1823	3612	1810	3738	1870
Алтанширээ	1297	627	1286	610	1262	599	1294	611
Даланжаргалан	2639	1331	2641	1314	2680	1320	2742	1352
Дэлгэрэх	1847	906	1868	908	1851	900	1889	922
Иххэт	2116	1067	2078	1047	2039	1011	2077	1035
Мандах	1565	754	1563	757	1566	757	1568	765
Өргөн	1921	948	1904	925	1889	887	1933	930
Сайхандулаан	1233	581	1276	595	1292	598	1367	628
Улаанбадрах	1482	733	1451	709	1431	699	1474	718
Хатанбулаг	2972	1463	2933	1452	2752	1357	2941	1456
Хөвсгөл	1584	793	1567	774	1518	743	1568	767
Эрдэнэ	2364	1129	2346	1120	2340	1079	2437	1164
Сайншанд	22011	11343	22666	11662	23191	11982	24059	12450
Замын-Үүд	15863	7840	16306	8073	15702	7881	17519	8636

1.5 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумаар, байршлаар, оны эцэст

	2013		2014		2015		2016	
	сумын төвд	хөдөөд	сумын төвд	хөдөөд	сумын төвд	хөдөөд	сумын төвд	хөдөөд
Бүгд	48024	14460	48532	14960	48154	14971	50999	15607
Айраг	2472	1118	2406	1201	2367	1245	2453	1285
Алтанширээ	323	974	309	977	305	957	298	996
Даланжаргалан	728	1911	688	1953	701	1979	711	2031
Дэлгэрэх	412	1435	391	1477	356	1495	355	1534
Иххэт	1170	946	1098	980	1018	1021	995	1082
Мандах	720	845	360	1203	345	1221	334	1234
Өргөн	1116	805	1085	819	1074	815	1066	867
Сайхандулаан	326	907	336	940	341	951	370	997
Улаанбадрах	352	1130	363	1088	347	1084	364	1110
Хатанбулаг	594	2378	583	2350	544	2208	573	2368
Хөвсгөл	421	1163	437	1130	421	1097	420	1148
Эрдэнэ	1516	848	1504	842	1442	898	1482	955
Сайншанд	22011	0	22666	0	23191		24059	
Замын-Үүд	15863	0	16306	0	15702		17519	

1.6 ӨРХИЙН ТОО, сумаар, байршлаар, оны эцэст

	2013		2014		2015		2016	
	Бүгд	үүнээс хөдөөд	Бүгд	үүнээс хөдөөд	Бүгд	үүнээс хөдөөд	Бүгд	үүнээс хөдөөд
Бүгд	18554	4449	19185	4694	20018	4878	20299	5205
Айраг	1111	360	1144	392	1183	420	1184	434
Алтанширээ	412	303	428	317	432	322	450	343
Даланжаргалан	851	629	875	663	919	689	930	695
Дэлгэрэх	504	394	524	413	534	425	551	441
Иххэт	668	297	674	311	702	338	708	360
Мандах	481	266	483	353	494	367	492	372
Өргөн	598	250	615	265	651	294	676	315
Сайхандулаан	387	282	407	294	436	316	461	328
Улаанбадрах	472	355	484	363	493	369	502	376
Хатанбулаг	908	716	903	712	884	697	932	734
Хөвсгөл	460	333	468	333	480	341	486	341
Эрдэнэ	674	264	708	278	765	300	785	466
Сайншанд	6529	0	6751	0	7087	0	7195	0
Замын-Үүд	4499	0	4721	0	4958	0	4947	0

Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга

1.7 ХҮН АМЫН ТОО, СУМААР, БАЙРШЛААР, 2016 онд

	Хүн амын тоо бүгд			аймгийн төв, тосгонд			сумын төвд			хөдөөд		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	66606	33302	33304	41578	20492	21086	9421	4710	4711	15607	8100	7507
Айраг	3738	1868	1870	0	0	0	2453	1227	1226	1285	641	644
Алтанширээ	1294	683	611	0	0	0	298	149	149	996	534	462
Даланжаргалан	2742	1390	1352	0	0	0	711	341	370	2031	1049	982
Дэлгэрэх	1889	967	922	0	0	0	355	169	186	1534	798	736
Иххэт	2077	1042	1035	0	0	0	995	480	515	1082	562	520
Мандах	1568	803	765	0	0	0	334	166	168	1234	637	597
Өргөн	1933	1003	930	0	0	0	1066	536	530	867	467	400
Сайхандулаан	1367	739	628	0	0	0	370	194	176	997	545	452
Улаанбадрах	1474	756	718	0	0	0	364	185	179	1110	571	539
Хатанбулаг	2941	1485	1456	0	0	0	573	279	294	2368	1206	1162
Хөвсгөл	1568	801	767	0	0	0	420	211	209	1148	590	558
Эрдэнэ	2437	1273	1164	0	0	0	1482	773	709	955	500	455
Сайншанд	24059	11609	12450	24059	11609	12450	0	0	0	0	0	0
Замын-Үүд	17519	8883	8636	17519	8883	8636	0	0	0	0	0	0

1.8 ХҮН АМЫН ТОО, СУМААР, НАСНЫ АНГИЛАЛААР, 2016 онд

	Хүүхэд 0-14 нас			Хөдөлмөрийн нас 15-59			тэтгэвэрийн нас 60<			үүнээс 85 <настай		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эр	эм
Бүгд	20423	10431	9992	42442	21334	21108	3741	1537	2204	139	34	105
Айраг	1096	560	536	2416	1219	1197	226	89	137	12	4	8
Алтанширээ	350	183	167	845	459	386	99	41	58	5	1	4
Даланжаргалан	857	432	425	1709	888	821	176	70	106	5	2	3
Дэлгэрэх	564	287	277	1205	638	567	120	42	78	3	0	3
Иххэт	595	316	279	1314	658	656	168	68	100	6	0	6
Мандах	444	220	224	1000	531	469	124	52	72	6	2	4
Өргөн	531	272	259	1285	686	599	117	45	72	4	1	3
Сайхандулаан	423	232	191	864	467	397	80	40	40	4	0	4
Улаанбадрах	404	196	208	938	507	431	132	53	79	4	1	3
Хатанбулаг	870	429	441	1899	986	913	172	70	102	13	2	11
Хөвсгөл	470	226	244	992	535	457	106	40	66	4	0	4
Эрдэнэ	729	374	355	1557	845	712	151	54	97	8	1	7
Сайншанд	7411	3798	3613	15051	7139	7912	1597	672	925	55	15	40
Замын-Үүд	5679	2906	2773	11367	5776	5591	473	201	272	10	5	5

1.9 ХҮН АМЫН ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, СУМААР, ОНЫ ЭЦЭСТ

	Хүн ам		Төрсөн хүүхдийн тоо			Нас барсан хүний тоо			Гэрлэлт		Цуцлалт	
	2015	2016	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	2015	2016	2015	2016
Бүгд	63125	66606	1527	805	722	391	241	150	325	330	62	67
Айраг	3612	3738	96	53	43	20	14	6	8	19	3	0
Алтанширээ	1262	1294	32	16	16	11	6	5	8	11	0	0
Даланжаргалан	2680	2742	64	43	21	17	9	8	8	9	1	2
Дэлгэрэх	1851	1889	44	23	21	17	13	4	12	10	1	2
Иххэт	2039	2077	51	29	22	19	12	7	3	13	2	2
Мандах	1566	1568	37	18	19	7	5	2	10	6	0	1
Өргөн	1889	1933	38	15	23	12	7	5	2	9	1	1
Сайхандулаан	1292	1367	48	30	18	6	3	3	8	5	0	0
Улаанбадрах	1431	1474	24	13	11	14	10	4	6	6	0	0
Хатанбулаг	2752	2941	61	31	30	11	7	4	9	12	1	2
Хөвсгөл	1518	1568	37	17	20	10	9	1	5	9	0	1
Эрдэнэ	2340	2437	57	29	28	12	6	6	7	7	3	3
Сайншанд	23191	24059	549	282	267	164	94	70	155	131	32	35
Замын-Үүд	15702	17519	389	206	183	71	46	25	84	83	18	18



1.10 ТӨРСӨН, НАС БАРСАН, ГЭРЛЭСЭН, ГЭРЛЭЛТЭЭ ЦУЦЛУУЛСАН ХҮНИЙ ТОО оны эцэст

Он	Төрсөн хүүхдийн тоо			Нас барсан хүний тоо			Гэрлэлт	Гэрлэлт цуцалсан
	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй		
2011	1525	761	764	423	289	134	244	62
2012	1587	798	789	373	248	125	291	62
2013	1582	833	749	374	227	147	323	42
2014	1673	878	795	387	249	138	363	88
2015	1667	848	819	350	236	114	325	62
2016	1527	805	722	391	241	150	330	67

1.11 1000 ХҮНД НОГДОХ төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, оны эцэст

	2011	2012	2013	2014	2015	2016
1000 хүнд ногдох төрөлт	25.4	26.1	25.6	26.5	26.5	23.5
1000 хүнд ногдох нас баралт	7.0	6.1	6.1	5.6	5.6	6.0
18 ба түүнээс дээш насны 1000 хү ногдох гэрлэлт	6.1	7.3	7.9	7.8	8.1	7.7
18 ба түүнээс дээш насны 1000 хү ногдох цуцлалт	1.55	1.55	1.03	1.49	1.54	1.56

1.12 1000 ХҮН АМД НОГДОХ ТӨРӨЛТ сумаар, оны эцэст

	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	25.4	26.1	25.6	26.4	26.3	23.5
Айраг	24.8	19.9	25.4	25.5	27.2	26.1
Алтанширээ	22.4	26.5	25.6	27.5	21.2	25.0
Даланжаргалан	24.0	27.6	21.3	32.7	25.9	23.6
Дэлгэхэр	22.7	23.5	25.5	24.2	28.0	23.5
Иххэт	23.9	23.9	25.8	18.0	15.5	24.8
Мандах	19.7	21.2	21.7	24.9	26.8	23.6
Өргөн	27.4	25.0	21.9	21.6	24.3	19.9
Сайхандулаан	30.5	26.1	28.1	26.5	24.1	36.1
Улаанбадрах	22.0	22.8	20.6	24.3	26.4	16.5
Хатанбулаг	21.1	25.9	20.3	18.6	20.1	21.4
Хөвсгөл	22.8	26.4	22.0	25.3	19.4	24.0
Эрдэнэ	22.1	20.0	19.2	23.5	17.1	23.9
Сайншанд	27.5	27.2	27.6	27.2	27.9	23.2
Замын-Үүд	25.5	28.6	27.4	28.6	29.1	23.4

1.13 1000 ХҮН АМД НОГДОХ НАС БАРАЛТ сумаар, оны эцэст

	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	7.0	6.1	6.1	6.1	5.5	6.0
Айраг	8.1	8.1	9.5	9.4	4.4	5.4
Алтанширээ	8.5	6.2	7.8	9.3	10.2	8.6
Даланжаргалан	4.6	5.8	7.2	4.9	6.0	6.3
Дэлгэрэх	7.2	8.7	7.0	4.8	5.9	9.1
Иххэт	8.9	7.5	3.8	6.2	4.4	9.2
Мандах	7.9	3.2	3.8	9.0	4.5	4.5
Өргөн	5.3	3.7	4.7	4.7	6.3	6.3
Сайхандулаан	4.1	7.6	2.5	5.6	4.7	4.5
Улаанбадрах	7.1	5.2	5.3	8.9	5.6	9.6
